

**“МАНДАТЫН ЭРХ, УИХ -ЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, БАЙЦААН ШИНЖИХ ТҮР  
ХОРОО, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, ХҮНИЙ ЭРХИЙН ОМБУДСМЭН, АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ  
ОМБУДСМЭН, ТӨСВИЙН АУДИТ” -ЫН ТУХАЙ**  
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

*У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн  
Ц. Түвшинзаяа, К. Пүрэвсүрэн*

## **Агуулга**

### **НЭГ. МАНДАТ БОЛОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ТУХАЙД**

1. Нэр томъёо, ойлголтын хувьд:
2. Эрх зүйн зохицуулалт

### **ХОЁР. БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРООНЫ ТАЛААР**

1. Бүгд Найрамдах Турк Улс
2. Бүгд Найрамдах Болгар Улс
3. Бүгд Найрамдах Унгар Улс

### **ГУРАВ. ТӨСВИЙН АУДИТ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ**

1. Ерөнхий ойлголт:
2. Үндсэн ойлголт:
3. Оросын Холбооны Улс
4. Бүгд Найрамдах Турк Улс

### **ДӨРӨВ. ОМБУДСМЭНИЙ ТУХАЙ**

1. Үндсэн ойлголт, чиг үүрэг
2. Омбудсмэнийг томилох ба түүний эрх зүйн байдал
3. Үйл ажиллагааны хамрах хүрээ
4. Санал гомдол гаргах, түүнийг шалгах хэрэг үүсгэх. Омбудсмэний бүрэн эрх
5. Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр

\* \* \*

### **НЭГ. МАНДАТ БОЛОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ТУХАЙД**

#### **Нэр томъёо, ойлголтын хувьд:**

Мандат буюу “mandate” /англи хэлээр/ бүрэн эрх, даалгавар /поручение/ гэсэн утгатай ба харин бүрэн эрх нь оросоор “полномочие”, англиар “authority”, германаар “Vollmacht” хэмээн утгын хувьд орчуулагдана. Эндээс “мандат” нь өөрөө бүрэн эрх гэсэн утгыг илэрхийлж буй тул “мандатын эрх” гэсэн томъёолол нь оновчгүй байна. Улсын орнуудын хууль тогтоомж, бусад мэдээллийн эх сурвалжаас судлан үзэхэд “мандат”, “гишүүний мандат” гэснээс биш, “мандатын эрх”, “гишүүний мандатын эрх” гэсэн нэр томъёо, агуулга байхгүй байна.

Мандат нь сонгуулийн эрхээр тодорхойлогдон ард түмэн буюу сонгогчдоос нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх зорилготой төлөөлүүлэх бүрэн эрх ба харин полномочие буюу бүрэн эрх нь хууль тогтоох чиг үүрэгт үндэслэсэн төрийн байгууллага, албан тушаалтны эдлэх, хэрэгжүүлэх эрх, үүргийн нэгдэл юм.

Хууль зүйн тайлбар толь, үндсэн хуулийн эрх зүйн ном, бүтээлд дараахь байдлаар тайлбарласан байна:

- Мандат (лат. *mandatum* англи. *mandate; credentials*) нь төлөөллийн хууль зүйн харьцаа, түүнчлэн эл төлөөлөл хууль ёсны болохыг нотолсон баримт бичиг. Парламентын гишүүний буюу депутатын мандат нь ямар нэгэн төлөөлөгчдийн байгууллагын гишүүний бүрэн эрхийн хууль ёсны байдал, бүрэн эрхийн хэр хэмжээ, тэдгээрийн эрх ба үүрэг, түүнчлэн Үндсэн хууль болон үндсэн хуулийн эрх зүйн бусад актаар тодорхойлсон парламентын гишүүний буюу засаг төрийн сонгуульт төлөөллийн бусад байгууллагын гишүүнд хүлээлгэсэн нийтийн чиг үүргийг нотолсон баримт бичиг. Мандат нь гишүүн ба түүний сонгогчдын хоорондын харилцааны шинж чанарыг тодорхойлно. Орчин үеийн улсуудад нийт улсын хэмжээний мандатыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өөрөөр хэлбэл, парламентын гишүүн нь ямар нэгэн тодорхой *сонгуулийн тойргийн бус*, харин нийт улсын хэмжээний төлөөлөгч гэж үздэг.
- Чөлөөт мандат – ардчилсан дэглэмтэй орнуудад парламентын гишүүд чөлөөт мандаттай байдаг. Өөрөөр хэлбэл, тэр өөрийг нь сонгосон тодорхой тойргийн сонгогчдоо бус, харин нийт ард түмнээ парламентад төлөөлдөг. Тийм ч учраас сонгогчид итгэл хөсөрдүүлсэн гэсэн үндэслэлээр түүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах журам байдаггүй.<sup>39</sup>
- ... нэгдүгээрт, сонгуульд ялсан нэр дэвшигч (сонгогдогч) УИХ-д ард түмнийг төлөөлөн суух бүрэн эрхийг сонгогчдоос хүлээн авдаг. Энэ тухай хуульд <<хамгийн олон гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцож>> тойргийн хороо бүртгэж, түр үнэмлэх олгоно /УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.4, 50.5/ гэж заасан. Энэ бол сонгогчдын өөрийн төлөөлөгчид олгож буй бүрэн эрх юм. Сонгогчдын олгосон бүрэн эрхийг нийтийн жишгээр **мандат** гэдэг. Хоёрдугаарт, сонгогдогч маань энэхүү мандатын үндсэн дээр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж, түүний өргөн мэдүүлснээр УИХ-ын чуулган хэлэлцэж гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч улмаар тангараг өргөснөөр хууль тогтоогчийн бүрэн эрх эхэлнэ. Сонгогчид нь өөрийн элчийг УИХ-д илгээхдээ олгодог бүрэн эрх нь парламентын шинж чанараас шууд хамаарч захирагдмал /"императив"/ мандат, чөлөөт мандат гэсэн 2 янз байдаг.
- Парламентын гишүүн нь гагцхүү тойргийнхоо сонгогчдын захиа даалгаврыг биелүүлэх үүрэгтэй, тийм учир тойргийн буюу нутгийн иргэдийн бүрэн эрхшээлд байдаг. Захиа даалгавар биелүүлээгүй гишүүнийг сонгогчид дуртай цагтаа огцруулдаг зарчимтай бол захирагдмал мандаттай гэнэ.<sup>40</sup> Тухайлбал: Германд парламентын гишүүний чиг үүрэг, ажлыг/албан тушаалыг Мандат гэх ба чөлөөт мандат, императив мандат ялгаатай байдаг. Бүлэг, эсхүл намын заавраар, эсхүл сонгогчдоос гишүүнд үүрэг хүлээлгэсэн бол императив мандат бий болно. Харин чөлөөт мандатын хувьд гишүүн журам, заавраас хамаарахгүйгээр зөвхөн өөрийн ухамсар, оюун ухаанд захирагддаг.

Бундестагийн гишүүд нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу чөлөөт мандатыг хэрэгжүүлдэг. Чөлөөт мандат нь нам, фракцууд, улс төрийн болон эдийн засгийн бусад бүлэглэлүүд, сонгогчдын бүлэглэл, мөн

<sup>39</sup> Д.Алтангэрэл. Англи-монгол толь. УБ., 2002 он, 298 дахь тал;

<sup>40</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. /Анхны хэвлэл/ УБ., 2007 он, 274 дэх тал; <http://www.uraljude.lawmix.ru/termins.php?id=1132>

сонгогчид гэх мэтийн нөлөөллөөс гишүүдийг хамгаалдаг ба түүний халдашгүй байдлыг баталгаажуулдаг.

Ийнхүү мандат, бүрэн эрх гэсэн 2 нэр томъёо нь ялгаатай бөгөөд зарим тохиолдолд хууль зүйн талаасаа давхцаж байна. Манай улсын хувьд давхцаж буй тэр байдлаар нь хууль тогтоомжид тусгасан. Өөрөөр хэлбэл, сонгогчдоос олгосон мандатыг гишүүний “бүрэн эрх” гэдэг агуулгаар нь хуульчилсан ч төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гишүүний бүрэн эрхээс нь ялгаж, гаргаж зохицуулаагүй юм.

Монгол Улсын Үндсэн хууль, УИХ-ын тухай хуульд “мандат” гэж үгчлэн тусгаагүй, гэхдээ “гишүүний бүрэн эрх”-ийн талаархи зохицуулалтаас “мандат”-ын агуулгыг харж болно. Жишээ нь: Монгол Улсын Үндсэн хуулийн 21, 23.2, 29.3 дахь хэсгээр дээр дурдсанчилан “чөлөөт мандат”-ын мөн чанарыг тодорхойлжээ. Хэдийгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.2, 12.1, 12.2, 25.1.2, 25.1.3, 25.6, 28.1, 47.3, 49.1.3-д “мандат”-ын талаархи шууд зохицуулттай харагдахаар байгаа ч энэ нь зөвхөн “хэлбэр”-ийг илэрхийлж, сонгуулийн тойргийг олон мандаттай байх тухай агуулгаар тусгажээ. Зарим нэг ялгааг энд дурдая. Үүнд:

1. Мандат /түүнд агуулагдсан бүрэн эрх/ нь сонгуулийн үр дүнд буюу сонгогчдоос хийсэн сонголтыг нотолсон баримт бичиг /манайхаар бол УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.5 дахь хэсэг/ -ийг сонгогдсон иргэнд олгосноор эхлэх ба харин парламентын гишүүний бүрэн эрх /төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой/ нь тангараг өргөсөн (Монгол Улсын Үндсэн хуулийн 23.2 дахь хэсэг)-өөр эхэлдгээрээ ялгаатай байх боломжтой. Тухайлбал, Туркэд эхний тохиолдолд гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл үүсдэг.
2. Зарим үед дээрх ойлголтууд нь давхцах тухай тэмдэглэсэн билээ. Учир нь гишүүний бүрэн эрх нь мандатын үндсэн дээр үүсч, парламентын гишүүний тангараг өргөснөөр “мандат” болон “гишүүний бүрэн эрх” цаг хугацааны хувьд нэг цэгт холбогдон хуулиар тогтоосон парламентын чиг үүрэг хэрэгжүүлэх, бодлого тодорхойлоход оролцон, үүнтэй холбоотой халдашгүй байдал олж авах, цалин, хангамж эдлэх болдог.
3. Мөн бас нэг ялгагдах зүйл гэвэл хэрвээ гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлвэл /тодорхой хугацаагаар/ түүний мандат нь түдгэлзэхгүй, хэвээр хадгалагдаж байх явдал юм. Өөрөөр хэлбэл, УИХ-ын тухай хуулийн 6.9-д заасан үндэслэлээр түдгэлзсэн бөгөөд шүүхийн шийдвэрээр гэм буруугүй нь тогтоогдвол бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба хэрэв гэм буруутай нь тогтоогдвол “гишүүний мандат”, “гишүүний бүрэн эрх” нь аль аль нь хугацаанаасаа өмнө дуусгавар болох үндэслэл болно гэсэн үг.
4. Судалгаанаас харахад мандатыг түдгэлзүүлэх гэсэн ойлголт, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Харин мандат эхлэх, дуусах /дуусгавар болох/, мандат хүчин төгөлдөр болох, мандатаа алдах талаар<sup>41</sup> улс орнууд хууль тогтоомждоо харилцан адилгүй зохицуулжээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9-д заасан гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх 2 үндэслэл нь бусад зарим улсын Үндсэн хууль, холбогдох хуульд парламентын гишүүний халдашгүй байдал /immunity/-ыг хасах, хязгаарлах үндэслэл болдог байна. Ийнхүү халдашгүй байдалд нь төрийн эрх бүхий байгууллагаас хууль ёсоор “халдах”-даа эрх бүхий субъектээс заавал зөвшөөрөл авах тохиолдол нь зонхилно. Өөрөөр хэлбэл, баривчлах, мөрдөн байцаах ажиллагааг явуулах, үргэлжлүүлэхийн тулд эхлээд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон гишүүний халдашгүй байдлыг нь хасуулах буюу хязгаарлуулах алхамыг хийх ба манайхаар бол Улсын ерөнхий прокурор (ихэнхи улс орнуудын хувьд ч)-оос саналаа оруулж зөвшөөрөл авснаар гишүүнийг хувь хүнийх нь хувьд

<sup>41</sup> Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он, 226 дахь тал

гэмт хэрэг үйлдсэн, эсэхийг шалган тогтооно.

Энэ тохиолдолд мөн л мандатыг нь түдгэлзүүлэх тухай яригддаггүй, харин зарим тохиолдолд парламентын чиг үүрэгтэй холбоотойгоор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх боломжтой байна. Жишээ нь: ОХУ-ын Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд “Холбооны зөвлөлийн гишүүн болон Төрийн думын депутат нь түүний бүрэн эрхийн нийт хугацаанд халдашгүй байна. Тэдгээрийг гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдах тохиолдлоос бусад үед сатуулах, баривчлах, нэгжих, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хуулиар тогтоосноос бусад тохиолдолд хувийн нэгжлэг хийж болохгүй”-г зааснаас харвал дээрх ойлголтыг буюу УИХ-ын тухай хуулийн 6.9-д заасан үндэслэлүүд нь юуны түрүүнд гишүүний халдашгүй байдалтай шууд хамааралтай, харин “гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх”-тэй шууд бус хамааралтайг нотолж байна.

### **Эрх зүйн зохицуулалт**

Дээрх асуудалтай холбоотойгоор эрх зүйн тогтолцоо төдийгүй төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, парламентын нэг танхимтай харьцангуй төсөөтэй зарим улсад эрх зүйн зохицуулалтын хувьд ямар байгааг товч гаргалаа.

#### **Словак Улс**

Тус улсын праламентын гишүүн нь төлөөллийн чөлөөт мандатыг хэрэгжүүлдэг. Мандат буюу бүрэн эрхийн талаар Үндсэн хууль, Үндэсний зөвлөл /парламентын/-ийн үйл ажиллагаа /процесс/-ны журмын тухай актаар зохицуулсан байна. Тухайлбал: мандат эхлэх, дуусах, парламентын гишүүд мандатаа алдах гэх мэт. Словакийн Үндсэн хуулийн 78, 81А дугаар зүйлд гишүүний мандатыг дуусгавар болох, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгохтой холбогдох асуудлыг зохицуулжээ.

Гишүүний бүрэн эрх болон мандатыг ялгаж ойлгохтой холбоотойгоор Үндсэн хуулийн 78.5 дахь хэсэгт “Хэрвээ гишүүн нь баривчлагдвал түүний мандат нь дуусгавар болохгүй ба зөвхөн хэрэгжүүлэхгүй.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, мандат нь дуусгавар болохгүй ч түүгээр олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй гэсэн агуулга юм. Үндсэн хуулийн 78.3-т зааснаар “Словак Улсын Үндэсний зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн болон сахилгын мөрдөн байцаах болон баривчлах ажиллагааг Депутатын хувьд явуулж болохгүй. Хэрэв Словак Улсын Үндэсний зөвлөл зөвшөөрөл олгохгүй бол депутатын мандатын үйлчлэх хугацаанд эрүүгийн мөрдөн байцаах болон баривчлах ажиллагааг явуулж болохгүй..” юм.

#### **Люксембург**

Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар “Ээлжит хуралдааны хугацаанд гэмт хэрэг үйлдэж буй газар дээрээ баригдсанаас бусад тохиолдолд нь зөвхөн Танхимын зөвшөөрлөөр депутатын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулж болно. Танхимын шаардсанаар чуулганы хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл байцаан шийтгэх ажиллагааг явуулахыг түр зогсооно.” гэжээ.

#### **Турк улс**

Үндсэн хуульд тодорхой зааж өгөөгүй боловч Парламентын гишүүний сонгуулийн тухай хуулийн 36.2 дахь хэсэгт зааснаар гишүүнээр сонгогдсон тухайн тойргийн сонгуулийн хорооноос гишүүнээр сонгогдсон тухай үнэмлэх олгосноор мандат нь эхэлнэ. Туркт парламентын тухай хууль байхгүй бөгөөд Үндсэн хуулийн 83, 84 дүгээр зүйлээр гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан ба 83.2-т “сонгуулиас өмнө болон дараа нь ямар нэг гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан

гишүүнийг Парламентын шийдвэргүйгээр барих, мэдүүлэг авах, баривчлах, шүүн таслахгүй. Хүнд гэмт хэргийг үйлдэл дээр нь болон сонгуулиас өмнө мөрдөн шалгаж эхэлсэн байх нөхцөлтэйгээр Үндсэн хуулийн 14 дүгээр заалтад заасан тохиолдлууд энэхүү заалтаас тусдаа байна. Гэвч энэ байдлыг холбогдох эрх бүхий байгууллага даруй, шууд Туркын Үндэсний Их Хуралд мэдэгдэнэ.”, 83.3-т “Гишүүний талаар сонгуулиас өмнө эсхүл дараа нь гарсан эрүүгийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг гишүүнчлэлийг нь дуусгавар болтол хойшлуулна.” гэж тус тус зохицуулжээ.

## ХОЁР. БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРООНЫ ТАЛААР

### 1. Бүгд Найрамдах Турк Улс

Ерөнхий сайд болон сайд нарын талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үйлдсэн гэмт хэрэгтэй нь холбогдуулан байцаан шалгах ажиллагааны талаар Парламентын мөрдөн шалгах ажиллагаа нэр дор Туркын Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд онцгой тохиолдлыг зохицуулсан байна. Уг зүйлд Ерөнхий сайд болон сайд талаар Туркын Үндэсний Их Хурлын бүх гишүүдийн аравны нэгээс багагүй гишүүн мөрдөн шалгах хүсэлт гаргаж болох бөгөөд ТҮИХ уг хүсэлтийг нэг сарын дотор хэлэлцээд, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Парламентын мөрдөн шинжих шийдвэр гарсан тохиолдолд парламент дахь улс төрийн намуудын, эвсэл хүчний харьцаагаар бүрдүүлсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй хороо мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Ерөнхий сайд, сайдын эрүүгийн хариуцлагатай холбоотой хянан шалгах механизм болох парламентын мөрдөн шалгах ажиллагаа нь мөн улс төрийн хариуцлагыг хамаарч байдаг. Учир нь Туркын Үндсэн хуулийн 113 дугаар зүйлийн дагуу ТҮИХ-ын шийдвэрээр Үндсэн хуулийн шүүхэд шилжсэн сайд сайдын албан тушаалаасаа огцрох ба Ерөнхий сайд Үндсэн хуулийн шүүхэд шилжсэн тохиолдолд Засгийн газар огцорсонд тооцдог байна.

Туркын Үндсэн хуульд парламентын мөрдөн шалгах ажиллагааг Ерөнхий сайд болон сайдын хувьд авч үзсэн байдаг боловч Туркын Үндэсний Их Хурлын дотоод дэгийн 107 дугаар зүйлд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа болон өмнө бүрэн эрх хэрэгжүүлж байсан Ерөнхий сайд, сайд нарын хувьд комисс байгуулан парламентын мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байдаг.

#### Парламентын мөрдөн шалгах хороог байгуулах:

Мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх шийдвэрийг ТҮИХ -аас гарсан тохиолдолд Үндсэн хуулийн дагуу нэр суглах замаар байгуулах 15 хүний бүрэлдэхүүнтэй комисс буюу хороог байгуулна. Хороо гишүүд дотроосоо дарга, орлогч дарга, хэвлэл, мэдээллийн төлөөлөгч, нарийн бичиг тус тус сонгоно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шүүгчийн шүүх хурлаас татгалзах тохиолдол, парламентын мөрдөн шалгах хүсэлт гаргасан, эсхүл өмнө нь ТҮИХ-д эсхүл хуралдаанаас тухайн асуудлаар гадна саналаа илэрхийлсэн гишүүнийг хорооны гишүүнээр сонгодоггүй. Хорооны ажиллах ажилтан, шинжээчдэд энэхүү шаардлага тавигдана.

#### Парламентын мөрдөн шалгах хорооны ажиллах журам болон хугацаа:

Хороо гишүүдийн олонхиор хуралдаж, хуралдаан оролцсон гишүүдийн олонхиор шийдвэр гаргана. Хорооны ажиллагаа нууц байна. Хорооны ажиллагаанд хорооны гишүүн бус парламентын гишүүн оролцож болохгүй. Тус хороо мөрдөн шалгах асуудлаарх тайланг хоёр сарын дотор ТҮИХ-д хүргүүлнэ. Хэрвээ мөрдөн шалгах ажиллагаа дээрх хугацаанд дуусаагүй тохиолдолд хоёр сарын хугацаа өгөх бөгөөд уг хугацаа эцсийнх байна. Энэ хугацаанд тайланг ТҮИХ-д хүлээлгэн өгөх шаардлагатай.

Парламентын мөрдөн шалгах хорооны бүрэн эрх: Хороо төрийн болон хувийн байгууллагаас асуудалтай холбоотой мэдээлэл, баримтыг хүсэх эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл хураан авч болно. Засгийн газрын бүх л хэрэгслийг ашиглаж болно, Засгийн газрын гишүүд, холбогдох бусад этгээд, гэрч, шинжээчийг сонсоно. Хороо төлөөлөгчөөр дамжуулан шүүхээр дэмжлэг хүсч болно. Түүнчилэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу гэрч, шинжээч, хураах, нэгжлэг хийхтэй холбоотой шүүхийн эрх чөлөөг хязгаарласан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг үндэслэлийг нь мэдэгдэн холбогдох шүүхээс бичгээр хүсч болно.

Хороо мөрдөн шалгах ажиллагаа хийгдэх талаар хүсэлт гаргуулсан Ерөнхий сайд, сайдын тайлбар /өөрийгөө хамгаалах/-ыг авна. Үүнтэй холбоотой хүссэн баримтыг нь бүрдүүлүүлнэ. Хороо шаардлагатай гэж үзвэл дэд хороо байгуулан Анкарагийн гадна үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргаж болно.

Мөрдөн шалгах ажиллагаа дуусгавар болох: Хороо тухайн асуудлаар тайлан гаргах бөгөөд уг тайланг ТҮИХ-ын даргад хүргүүлснээс өдрөөс 10 хоногийн дотор тараах ба тарааснаас эхлэн 10 хоногийн дотор хэлэлцүүлнэ. Энэхүү хэлэлцүүлэгд хороо болон тухайн хүний нэрийн өмнөөс 6 гишүүн мөн тухайн үед бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа эсхүл хэрэгжүүлээгүй байгаа өөрт нь парламентын мөрдөн шалгах ажиллагаа хийхээр хүсэлт гаргуулсан Ерөнхий сайд, сайд үг хэлэх бөгөөд сүүлийн үгийг асуудалд холбогдсон Ерөнхий сайд, сайд хэлэх ба хугацааг нь хязгаарлахгүй.

Хэлэлцүүлэг дууссаны дараа хорооны тайланг Нэгдсэн хуралдаанаар нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Хорооны Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх талаархи тайлан, Нэгдсэн чуулганаар Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх шийдвэрт эрүүгийн хуулийн ямар зүйлийг үндэслэж буйг дурдана. ТҮИХ бүхий гишүүдийн олонхийн нууц саналаар Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх шийдвэрийг гаргана. Парламент дахь улс төрийн намын бүлгүүд парламентын мөрдөн шалгахтай холбоотой хэлэлцүүлэг хийхгүй ба шийдвэр гаргахгүй. ТҮИХ Үндсэн хуулийн шүүхэд асуудлыг шилжүүлэх шийдвэр гаргасан тохиолдолд баримтыг 7 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхийн даргын ажлын албанд илгээнэ.

## 1. Бүгд Найрамдах Болгар Улс

БНБУ-ын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт Үндэсний Ассамблей нь байнгын болон түр хороодтой байхаар заасан 79.3 дахь хэсэгт мөрдөн, байцаан шалгах түр хороог гэж сонгохоор заасан байна. Болгарын Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, процедурын дүрэм /дэг/-ийн 99 дүгээр зүйл парламентын мөрдөн, байцаан шалгах болон сонголыг тусгайлан зохицуулсан байна. Төрийн болон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар Үндэсний Ассамблей мөрдөн, байцаан шалгах түр хороог сонгоно.

Засгийн газрын бүх л харъяа байгууллага, төрийн байгууллага, захиргааны байгууллага, гишүүд Үндэсний Ассамблейн мөрдөн шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Түүнчилэн шүүх, төрийн нууцтай холбоотой мэдээллийг хүртэл гаргуулна.

Засгийн газрын бүх бүрэлдэхүүнүүд, төрийн захиргааны болон хотын удирлагууд, олон нийтийн байгууллагууд, түүний гишүүд бүгд мөрдөн, байцаан шалгахтай холбогдох баримтууд болон мэдээлэл, лавлагаанууд, түүнчилэн тухайн мэдээлэл улсын, албаны эсвэл шүүхийн нууцлалтай байсан ч бэлэн байлгах үүрэгтэй. Мөрдөн, байцаан шалгахтай холбогдох мэдээллийг гаргах журмыг Үндэсний Ассамблей эсхүл мөрдөн, байцаан шалгах түр хороо тогтоох бөгөөд Үндэсний Ассамблейн тухайн хороо олон нийтийн байгууллагын гишүүд, албаны хүмүүсийг урьж мэдээлэл авах

ба эдгээр этгээд нь хороог шаардлагатай баримт, мэдээллийг хангана. Тус уулзалт, хурлыг Үндэсний Ассамблейн ажлын албад зохион байгуулахаар злхицуулсан байна.

## 1. Бүгд Найрамдах Унгар Улс

БНУУ-ын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт Парламент байнгын хороог парламентын гишүүдээсээ сонгох бөгөөд аливаа асуулыг мөрдөн шалгах зорилгоор хорооны гишүүнийг томилохоор заасан байна. Үндсэн хуулийн тус заалтын дагуу Унгарын Парламентийн Байнгын хорооны дүрэм /46/1994 (IX.30.)/-ийн 34 дүгээр зүйлд түр хорооны асуудлыг зохицуулсан байна. Аливаа асуудлыг мөрдөн, хянан шалгахгаар Парламентаас мөрдөн шалгах хороо томилон ажиллуулах бөгөөд тодорхой хугацааны дотор хороо байгуулах тухай тогтоол гарган уг тогтоолд тодорхойлогдсон асуудлуудыг хариуцуулахаар түр хороо томилж болно. Мөн түр хороо байгуулах тухай тогтоолд дараахь асуудлаар өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлж болохгүй:

- Мөрдөн, хянан шалгах асуудал, Хянан шалгах хорооны нэр,
- Түр хорооны нэр болон зорилтуудын хүрээнд багтсан асуудал.

Мөрдөн, хянан шалгах биетийн тодорхойлолт, нэр, үйл ажиллагаа, батлах болон хянан шалгах хороог татан буулгах, мөн үүнтэй адил түр хорооны зохицуулалт зэрэг нь Парламентын тогтоолд тусгайлан заагаагүй бол Дүрмийн 36 зүйл үйлчилнэ. Парламентын гишүүдийн 5-ны нэгээс багагүй нь дэмжсэн тохиролдолд хянан шалгах хороог байгуулж болох бөгөөд тус хорооны гишүүдийг зөвхөн Парламентын гишүүдээс сонгоно. Хянан шалгах хороог байгуулахдаа Дүрмийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн үндэс болгоно. Засгийн газар, аль нэг Засгийн газрын агентлаг эсвэл яамны үйл ажиллагаа, эсхүл сайдын талаар мөрдөн шалгах хянан шалгах хороог Парламентын сөрөг хүчний гишүүн даргалана. Хэрэв мөрдөн шалгах нь хамтарсан Засгийн газрыг хамаарах бөгөөд Засгийн газрын сөрөг хүчин нь тэгш бус тохиолдолд хянан шалгах хороог Засгийн газрын сөрөг намуудад харъяалагдах гишүүд хамтран удирдана.

Хамтарсан удирдлагууд хорооны хуралдааныг хамтран бэлтгэх ба хуралдааныг ээлжээр даргална. Тэд Хурлын даргын бусад үүргүүдийг хамтран гүйцэтгэх бөгөөд хамтарсан удирдлагын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. Хянан шалгах хороо нь дараахь агуулга бүхий үйл ажиллагааныхаа тайланг гаргана:

- Хорооны зорилго,
- Хорооны үйл ажиллагааны журам, мөрдөн шалгахтай холбоотой баримтыг олж авах процедур, арга зүйг тогтооно,
- Хорооны олж тогтоосон фактууд болон хорооны үйлдсэн хууль зүйн баримт бичиг,
- Чиг баримжаануудыг гаргахад үндэслэсэн нотолгооны танилцуулга,
- Мөрдөн шалгахад тогтоосон асуудлын талаар хувь хүн эсвэл албан байгууллагын гаргасан тайлбар,
- Мөрдөн шалгахтай холбоотой тогтоосон асуудал нь хорооны үйл ажиллагааны зорилгод хамаарсан тохиолдолд хорооноос авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ.

Унгар Улс нь аливаа нэг асуудлаар хянан шалгах талаар парламентын гишүүдээсээ сонгосон түр хороог байгуулж ажилладаг байна. Уг хороог сөрөг хүчний гишүүн эсхүл хамтран даргалдаг байна. Хороо тайлан бэлтгэн гаргадаг байна.

\*\*\*



## ГУРАВ. ТӨСВИЙН АУДИТ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

## 1. Ерөнхий ойлголт:

Төсөв нь өөрийн шинж төрхөөрөө улс төрийн баримт бичиг юм. Төсвийн санал гарах, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын чиг үүргийг хязгаарлах зэрэг нь төсвийг улс төрийн баримт бичгийн шинжтэй болгодог. Энэ нь парламентаас гүйцэтгэх засаглалд олгож буй ирээдүй үеийн удирдлагын төлөвлөгөө буюу удирдлагын хөтөлбөр юм.

Парламентын засаглалтай орнуудад төсвийг дэмжсэн санал өгөх нь парламентын гишүүдийн олонхийн зүгээс Засгийн газарт итгэл үзүүлж буйн илрэл гэж үздэг.<sup>42</sup> Төсөв гэдэг нь “Төрийн байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хэлбэр”, “мөнгөн хөрөнгийн төвлөрсөн үндсэн сан”<sup>43</sup>, “...санхүүгийн төлөвлөгөө, ... санхүүгийн чухал зохицуулагч, ... мөнгөн харилцааны нийлбэр цогц ... юм.”<sup>44</sup>

Төсөв нь өргөн хүрээний санхүүгийн категори учир санхүүд хамаарах бүх чиг үүргийг *нэгдүгээрт*, төсвийн санг бүрдүүлэх /орлого/, *хоёрдугаарт*, төсвийн санг зарцуулах /зарлага/, *гуравдугаарт*, хянах чиг үүргийг гүйцэтгэдэг.

## 2. Үндсэн ойлголт:

Төрийн хяналтын нэг хэлбэр бол Парламентын хяналт юм. Парламентын хяналтын онцгой төрлийн нэг бол санхүүгийн болон санхүүгийн эдийн засгийн хяналт юм байна. Үүнийг парламентын тусгай байгууллагаар буюу тооцооны танхим /төсвийн аудит/, тооцооны шүүхээр хэрэгжүүлдэг. Парламентын хяналт захиргааны шинжтэй.<sup>45</sup> Сүүлийн арваад жилд хүний эрхийг Парламентын хяналтаар хангадаг болсон байна.

## Оросын Холбооны Улс

1995 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр баталсан ОХУ-ын тооцооны танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Тооцооны танхим /төсвийн аудит/ нь ОХУ-ын Холбооны хурлаар байгуулагдаж, улсын санхүүгийн хяналтыг тогтмол хийж, дээрхи хуралд ажлаа тайлагнана.”

**Тооцооны танхим:** Холбооны Улсын төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэг хэрэгжүүлэхдээ хуулийн үндэслэлтэй, бодит, хараат бус болон ил тод байх зарчмыг баримтлан гүйцэтгэнэ. Мөн дээрхи хуулийн 2 дугаар зүйлд:

- Холбооны Улсын төсөв болон төсвийн бус Холбооны Улсын сангуудын орлого зарлагын гүйцэтгэлийн хэмжээ, бүтэц, зориулалтыг хянах ажлыг зохион байгуулна;
- Улсын хөрөнгийн зарцуулалт болон улсын өмчийн ашиглалтын үр дүнг зохистой эсэхийг тодорхойлох;
- Холбооны Улсын төсөв болон төсвийн бус сангуудын төслүүдийн орлого зарлагын үндэслэлийг үнэлэх;
- Холбооны Улсын хуулийн төсөл болон төрийн байгууллагуудаас гаргаж буй эрх

<sup>42</sup> Б. Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он, 208 дахь тал

<sup>43</sup> <http://www.ipu.org/parline-e/parlinelist.asp?newquery=yes&typeform=Search>

<sup>44</sup> Отгонтуяа. Л. Төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлт. УБ., 2007. 4 дэх тал

<sup>45</sup> Основы теории финансов /Под ред. Л.А. Дробозиной, М., Банки и Брижи: ЮНИТИ, 1995.с.32



зүйн актуудад санхүүгийн дүн шинжилгээ хийнэ. Энэхүү зардал нь Холбооны Улсын төсөвт суусан байх ёстой.

- Холбооны Улсын төсөв болон Холбооны Улсын төсвийн бус сангуудыг төсвөөс тогтоосон үзүүлэлтээс хэтэрсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж тэдгээрийг арилгахад чиглэсэн, мөн төсвийн үйл ажиллагааг бүхэлд нь боловсронгуй болгох саналыг бэлтгэх;
- ОХУ-ын Төв банк, ОХУ-ын бүрэн эрхт томилогдсон банк болон санхүү, зээлийн бусад байгууллагуудын хөрөнгийг цаг тухайд нь хөдөлгөж буй болон хуулийн үндэслэлтэй байгаа эсэхийг хянах;
- Холбооны Улсын зөвлөл болон Төрийн Думд Холбооны Улсын төсвийн гүйцэтгэл болон хяналтын үйл ажиллагааны тайланг тогтмол гаргана гэж Тооцооны танхимын эрх хэмжээг тодорхойлжээ.

### Бүгд Найрамдах Турк Улс

БНТурк улсын хувьд нь төсвийн аудитыг Тооцооны шүүхийн тухай 1967 оны 832 дугаар хуулиар зохицуулсан бөгөөд уг шүүх нь ерөнхий болон холимог төсөвтэй газрын орлого, зарлага болон эд хөрөнгийг нь ТҮИХ-ын нэрийн өмнөөс хянан, хариуцлагыг тооцоо болон ажиллагааг нь шүүн таслах журмаар эцэслэн шийдвэрлэж, хуулиар олгосон хянан судалж, шалгаж, шийдвэрлэх ажлыг гүйцэтгэх үүрэгтэй байдаг байна. *Тооцооны шүүхийн зохион байгуулалтад хамаарагдах нэгжүүд:*

1. Тойрогууд;
2. Тойргын зөвлөл;
3. Давж заалдах хороо;
4. Ерөнхий хороо;
5. Дээд сахилгын хороо;
6. Албан хаагч сонгох болон Сахилгын хороо.

Төрийн сангийн нэрийн өмнөөс прокурор энэхүү байгууллагад хамаарагдана. Тооцооны шүүхийн чиг үүрэг: Ерөнхий болон холимог төсөвтэй байгууллагын, тус байгууллагын хөрөнгийн хагас болон хагсаас нь илүүг хувийг оролцуулах хэлбэр бүхий тогтсон болон эргэлтийн хөрөнгөтэй эсхүл сан хэлбэрээр байгуулсан байгууллага, бусад хуулиар Тооцооны шүүхийн хяналтад хамааруулсан бусад байгууллагын орлого, зарлага, эд хөрөнгө, бэлэн мөнгө, өрийн бичиг, үнэт цаас зэрэг үнэт зүйлсийг авч, өгөх, хадгалах болон ашиглахыг нь хянан шалгана. хариуцлагыг тооцоо болон ажиллагааг нь шүүн таслах журмаар эцэслэн шийдвэрлэнэ.

Төрд холбогдох тооцоо, төрөл бүрийн эх сурвалжаас хандив, тусламж зэргээр орж ирсэн бэлэн болон бэлэн бус материаллаг үнэт зүйлсийг, Төрийн боно, батлан даалт, зээл, төрийн авансийн бүртгэлийн хянаана. Ерөнхий болон холимог төсөвтэй байгууллагатай холбоотой ерөнхий хэрэгжилтийн мэдэгдлийг Үндсэн хуульд заасан хугацаанд ТҮИХ-д хүргүүлнэ. Тооцооны шүүх хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тооцооны шүүхийн бүрэн эрх: Тооцооны шүүх хуулиар тогтоосон үүргээ хэрэгжүүлэхдээ яамд, байгууллага, нутгийн захиргааны удирдлага, тооцооны ажилтан бусад холбогдох хариуцлагатай ажилтнаас шууд бичгээр, шаардлагатай баримт, дэвтэр, бүртгэлийг үзэх, хүсвэл газар дээр нь авчруулах, амаар мэдээлэл авах, зэрэг бүх л зэрэг дэвтэй төрийн албан хаагчийг дуудах, яамд байгууллагаас төлөөлөгч илгээхийн хүсэх эрхтэй. Тооцооны шүүхийн хянан шалгах ажиллагаатай холбоотой бүх л төрлийн мэдээлэл, баримтыг Төрийн бүх байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, зэрэг бүх л төрийн байгууллага, болон бусад хувь хүн, хуулийн этгээд /банк хамаарна/-ээс хүсэж авна.

## ДӨРӨВ. ОМБУДСМЭНИЙ ТУХАЙ

Омбудсмэн – эрх зүйн тайлбар толь болон бусад эх сурвалжид бичсэнээр, “янз бүрийн захиргааны байгууллагаас хүний эрхийг сахин хангаж байгаад хяналт шалгалт хийхээр тусгайлан сонгогдсон /томилогдсон/ албан тушаалтан, гадаадын зарим улсад хувь хүн ба нэгдэл”, мөн “нийтийн эрх ашгийг хохироосон үйл ажиллагаанд иргэдээс гаргасан гомдол, хүсэлтэд хариу өгөх, шинжлэн судлахаар төрөөс томилогдсон албан тушаалтан”<sup>46</sup>, “төрийн байгууллага болон албан тушаалтны хүнд суртал, шударга бус үйл ажиллагааны талаар иргэдээс гаргасан гомдлыг магадлан шалгадаг хараат бус, олон нийтийн албан тушаалтан”<sup>47</sup> гэжээ.

Улс бүхэнд нэрлэх нэр томъёоны хувьд өөр байдаг ч явуулж буй үйл ажиллагааны хувьд бүгд төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хүний эрхийг зөрчсөнтэй холбоотой бүхий л гомдлыг хариуцдаг.

### Хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгч

Хүний эрхийг хамгаалах институт болох омбудсмэны институт нь анх 1809 онд Засаг захиргааны тухай Актын 6 дугаар зүйлийг үндэслэн байгуулагдсан. Энэхүү Актаар хууль бусад шийдвэрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих нэг юмуу хэд хэдэн омбудсмэныг сонгох үүрэг Шведийн парламент Риксдагт оногдсон болно. Хожим омбудсмэний институт өргөжин тэлж эхэндээ хойт Европын орнуудад, тухайлбал 1919 онд Финландад, 1954 онд Данид, 1960-1980-аад онд дэлхий нийтэд түгээмэл дэлгэрсэн хяналтын тогтолцоо болж хөгжсөн байна.

Гэхдээ Данийн омбудсмэний тогтолцоо Шведийнхээс арай өөр бөгөөд дэлхий нийтэд түгэн тархсан омбудсмэний тогтолцооны суурь загвар болжээ. 1962 онд Шинэ Зеландад, 1967 онд Их Британи болон Канадын зарим мужид, 1969 онд Хавайн арлуудад, 1971 онд АНУ-ын мужуудад, Австралийн хойт, өмнөд Мужид, 1973 онд Францад, 1976 онд Португали, 1981 онд Испани, 1982 онд Голландад тус тус байгуулагджээ. Харин сүүлийн жилүүдэд Польш (1988), Унгар (1989) зэрэг шилжилтийн үеийн улс орнуудад болон Ази, Африкийн хөгжиж буй орнуудад ч байгуулагдаж байна.

### Омбудсмэний тогтолцооны онцлог:

Бүтцийн хувьд маш уян хатан, амар хялбар өөрчлөгдөж байдаг. Скандинавын улсуудад “Омсудсман”, Испани, Колумбид “ард түмний хамгаалагч”, Их Британид “парламентын Бүрэн эрхт элч”, Энэтхэгт “ардын элч” буюу локпал, Францад “зуучлагч”, Румынд “ард түмний өмгөөлөгч”, Нигерид “Олон нийтийн санал гомдлын хороо”, Австри зэрэг зарим оронд хяналтын талаархи үндсэн зарчмыг хадгалсан хамтын удирдлагын тогтолцоо ч болж өөрчлөгдөн хөгжсөн байдаг. Өөрөөр хэлбэл омбудсмэний тогтолцоо нь эрх зүйн ямар ч тогтолцоонд зохицдог өвөрмөц онцлогтой юм.

Ардчилсан нийгэмд омбудсмэн нь төрийн захиргааны байгууллага болдоггүй. Омбудсмэны тогтолцоо нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хэрэгжүүлдэг нэлээд үр нөлөөтэй байгууллага болдог байна. Гэхдээ төрийн байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих биш, гагцхүү тэдгээрээс иргэд, олон нийттэй харилцах харилцаанд иргэдийн эрх зөрчигдөж буй тохиолдолд хяналтын үүргээ хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Янз бүрийн улс оронд омбудсмэний тогтолцоо, түүний чиг үүрэг харилцан адилгүй байвч ерөнхийдөө араг яс нь адил гэж хэлж болно. Иргэдийн

<sup>46</sup> Финансы и кредит/ Под ред. А.Ю. Казака. Екатеринбург, 1994.с.170

<sup>47</sup> <http://www.uraljude.lawmix.ru>

санал гомдлыг барагдуулах талаархи омбудсмэний нийтлэг чиг үүргийн талаар гэвэл:

1. Хяналтын үйл ажиллагаа
2. Төр, иргэний хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд тус дэм болох үйл ажиллагаа (function of conflict-resolution)
3. Өөрчлөн байгуулах, шинэчлэх үйл ажиллагаа гэсэн үндсэн гурван чиглэлтэй байдаг.

Зарим тайлбар хийхэд омбудсмэн хяналтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага шиг биш харин иргэдийн эрх зөрчигдөж байгаа талаар гаргасан гомдлын мөрөөр хяналт хийх болон зарим тохиолдолд омбудсмэний өөрийнх нь санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаа явуулдаг байна. Үйл ажиллагааны хоёр дахь чиг үүргийн тухайд гэвэл тус дэм, нөлөө үзүүлэх гэдэг нь илүү оновчтой томъёолол байж болох талтай. Учир нь омбудсмэний гаргасан шийдвэр нь тухайн зөрчлийг зайлшгүй шийдвэрлэх императив хүчинтэй баримт бичиг болдоггүй бөгөөд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд уг зөрчлийг хэрхэн арилгах талаар зөвлөмж болдог. Тиймээс энэ нь үнэн чанартаа шүүхийн шийдвэр шиг заавал биелүүлэх хүчинтэй биш харин зөрчлийг арилгахад тус нөлөө үзүүлэх чиг үүрэгтэй гэж үзэж болох юм.

Гурав дахь чиг үүргийн тухайд тодруулахад омбудсмэний үйл ажиллагааны өөрчлөх, шинэчлэх чиг үүрэг нь түүний арга ажиллагаатай салшгүй холбоотой гарч ирдэг өвөрмөц онцлог юм. Яагаад гэвэл омбудсмэний нөлөө нь түүний эрх мэдэлд бус, харин парламент, олон нийтийн санаа бодол болон өөрийнх нь нэр хүндэд тулгуурладаг юм. Тиймээс түүний энэ чиг үүрэг маш чухал нөлөөтэй байдаг ажээ. Ихэнхи улс оронд омбудсмэн нь парламентын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, парламентад жил бүр тайлангаа тавьдаг. Ингэснээр иргэдийн санал гомдол гардаг, иргэдийг бухимдуулж буй “зөрчилтэй газар” нийгмийн харилцаа хаана байгааг мэдээлэх хийгээд тэнд төрийн аппаратыг өөрчлөн сайжруулах шаардлагатайг мэдээлдэг ач холбогдолтой юм.

Омбудсмэний үйл ажиллагаа нь дээд зэргээр нээлттэй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй нягт холбоотой явагддаг. Иймд омбудсмэний үйл ажиллагаа нь иргэд, төрийн байгууллагуудын харилцааг илүү ойр дөт болгох, харилцан ойлголцолыг бэхжүүлэх, төрийн түшмэлүүдийн иргэдтэй харилцах харилцааг өөрчлөн сайжруулах үр нөлөөтэй хүчин зүйл болдог юм. Омбудсмэний тогтолцоо улс орон бүрт харилцан адилгүй, олон хэв шинж, хувилбартай байдаг. Гэсэн ч тэдгээрээс нийтлэг шинж байдлыг авч үзвэл:

### 1. Омбудсмэнийг томилох ба түүний эрх зүйн байдал

Омбудсмэний тогтолцооны олон хувилбарт, хэв шинжит байдал ба онцлог нь түүнийг сонгох процедурт нэгэн адил тусгалаа олдог байна. Түүнийг томилдог хамгийн их түгсэн “сонгодог” хэлбэр нь гэвэл парламентаар томилдог хэлбэр юм. Олон оронд албан тушаалтны жагсаалтад омбудсмэнийг Парламентын Омбудсмэн (Финланд), Фолькетингетс Омбудсмэн (Дани), Парламентын Бүрэн эрхт элч (Их Британи) зэргээр оруулсан байдаг.

Омбудсмэний бүрэн эрхийн хугацаа нь гол төлөв парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаатай дүйцэх буюу 4-6 жил байдаг. Финландад эхэндээ нэг жилийн хугацаатай сонгогддог байснаа 1933 оноос гурван жилээр, 1957 оноос 5 жилийн хугацаатай болжээ. Харин Испанид 5 жилийн хугацаагаар сонгодог бол Туркэд парламентын сонгуулийн 5 жилийн хугацаанд 2 удаа буюу эхний гишүүн 2, дараагийн сонгогдох гишүүн 3 жилийн хугацаатай тус тус сонгогддог байна.

Зарим улс оронд омбудсмэнийг томилдог процедур нь арай өөр, омбудсмэний тогтолцоо нь гүйцэтгэх засаглалдаа илүү ойртсон шинжтэй байдаг. Жишээ нь, Шинэ Зеландад омбудсмэнийг парламентын санал болгосноор генерал-губернатор томилдог ажээ.

Европын орнуудаас гүйцэтгэх засаглалдаа илүү ойр байдаг нь Францын хэлбэр юм. Францад Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр Медиаторыг (посредник буюу холбогч, зуучлагч) 6 жилийн хугацаагаар томилдог байна. Харин Суданаас бусад Африкийн ихэнхи оронд омбудсмэнийг Засгийн газар эсхүл Ерөнхийлөгч томилдог байна. Намибид ерөнхийлөгчөөс томилдог байна.

Харин Туркийн “Хүний эрхийн хянан шалгах хороо”-г Үндэсний Их Хурлын /ҮИХ/ байнгын хорооны хэлбэрээр байгуулахаар дотоод дэгийн хуулиндаа тусгасан байдаг бөгөөд үйл ажиллагааных нь зарчмыг бие даасан хуулиар тусгайлан зохицуулдаг. Тус хорооны гишүүдийн тоог Туркийн ҮИХ-ын даргын дэргэдэх Зөвлөх хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар тогтооно. Хорооны бүрэлдэхүүнийг улс төрийн намын бүлгүүд болон бие даагч нарыг бүх гишүүний тоонд харьцуулан гарах хувиар тооцон тохирохоор төлөөлнө. Ихэнхи орны омбудсмэний тухай хуулиудад түүнийг томилоход тусгай шаардлага тавьдаггүй.

Харин омбудсмэнээр ажиллахад нэлээдгүй хязгаарлалтыг хуульчилсан байдаг байна. Тухайлбал, Польшоос бусад оронд омбудсмэн нь парламентын гишүүн байж болохгүй, улс төрийн, арилжааны чиглэлийн үйл ажиллагаа болон ямарваа нэг өөр ажил алба эрхлэхгүй байх гэх зэрэг. Омбудсмэний парламентын болон олон нийтийн өндөр статус нь парламентын гишүүний халдашгүй байдалтай адил зарим төрлийн баталгаа, халдашгүй байдлын баталгааг хуулиар зохицуулсан байдаг. Түүнчлэн Омбудсмэний тухай хууль тогтоомжуудад түүний үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулж өгсөн байдаг.

Ялангуяа үүнд санхүүгийн болон улс төрийн талаар хараат бус байх зарчмыг онцлон авч үздэг байна. Тухайлбал, омбудсмэн хүнд хэнч тодорхой санал гомдлын мөрөөр шалгах, барагдуулахад ямарваа нэг зөвлөмж өгөх эрх байхгүй гэдгийг хуульчилж өгсөн байх жишээтэй. Тиймээс омбудсмэнүүд зөвхөн парламентад ажлаа хариуцаж тайлагнадаг байна. Засгийн газраас томилогддог омбудсмэнүүд Засгийн газартаа тайлагнана. Харин хуульд омбудсмэнийг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь чөлөөлөх, өөрийн хүсэлтээр огцруулах, цаашид үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй гэж үзэх, гэмт хэрэг үйлдэх зэрэг зохицуулалтыг нэлээд сайн оруулж өгдөг байна.

#### **Үйл ажиллагааны хамрах хүрээ /Юрисдикция/**

Омбудсмэний үйл ажиллагааны хамрах хүрээ нь улс орнуудад харилцан адилгүй байдаг. Швед, Финланд зэрэг оронд анх омбудсмэний тогтолцоо үүсч хөгжихдөө үйл ажиллагааны хүрээ нь зөвхөн гүйцэтгэх засаглалын засаг захиргааны байгууллагаар хязгаарлагдахгүй шүүх, хорих газар, цэргийн байгууллагыг хүртэл хамарч байсан. Тэгвэл өнөө үед ихэнхи оронд омбудсмэн нь зөвхөн Засаг захиргааны төв болон төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хүрээг хамардаг.

Дани, Финланд, Канадын зэрэг зарим оронд омбудсмэний хяналтын үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын гишүүд, прокурорын байгууллага хамрагддаг. Их Британи, Франц, Шинэ Зеланд зэрэг оронд орон нутгийн засаг захиргааны удирдлагын үйл ажиллагааг хамрана. Их Британи, Испани зэрэг оронд улсын ерөнхий омбудсмэний ажил бүс нутгийн болон орон нутгийн омбудсмэнүүдийн үйл ажиллагаатай уялдаа холбоотой байдаг.

Зарим оронд омбудсмэний төрөлжсөн байгууллага байгуулагдах практик нэвтэрч байна. Тухайлбал, Норвеги, ХБНГУ, Финлянд, Португал, Австрали зэрэг оронд батлан хамгаалахын омбудсмэн, Израйльд цэргийн талаар ирүүлсэн өргөдөл гомдол хариуцсан офицер, Канадын Үндэсний батлан хамгаалах департамент болон зэвсэгт хүчний омбудсмэн, АНУ зэрэг улсуудад пенитенциарын системд тавих хяналт, Шведэд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэх мэт.

**Зарим орон дахь батлан хамгаалахын омбудсмэний хяналт**

Улс	Эрх мэдэл	Үүрэг	Тайлан ба улс төрийн албан тушаалтны үүрэг
Австрали	Батлан хамгаалах хүчний омбудсмэн сайд нарын шийдвэрээр томилно	Австралийн батлан хамгаалах хүчний гишүүдийн аливаа буруу үйлдлийг хянах	Парламентад суугаа төлөөний сайдад жилийн ажлын тайланг тавих
Канад	Батлан хамгаалахын омбудсмэн сайд нарийн зөвлөлийн шийдвэрээр томилно	Үндэсний батлан хамгаалах департментийн ажилтан, албан хаагчид ба Канадын Зэвсэгт хүчний гишүүдийн эрхийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> <li>Онцгой тохиолдолд Үндэсний батлан хамгаалахын Департмент буюу Канадын Зэвсэгт хүчинд тайлан тавих, үйл ажиллагааны талаар сайдад жилийн тайланг тавих;</li> <li>Төвийг сахигч ба бодит зөвлөл. Батлан хамгаалахын сайдын удирдлагаас хараат бус байх</li> </ul>
Норвеги	Батлан хамгаалахын омбудсмэн Норвегийн парламентын хүрээнд сонгоно	Цэргүүдийн эрх ашгийг хамгаалах, батлан хамгаалах байгуулалтын төрөл бүрийн салбарын хүрээнд үүссэн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд анхаарлаа төвлөрүүлэх	Сайн дураар холбогдох олон нийтийн байгууллагад зөвлөмж, үнэлгээ, шүүмжлэл өгөх

\* \* \*

Сүүлийн 10 жилд Орост хүний эрхийг хамгаалах тухай асуудлыг парламентын хяналт буюу омбудсмэнээр хэрэгжүүлэх болсон. Тодруулбал, Аюулаас хамгаалах салбар болон батлан хамгаалах салбар дахь захиргааны гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагаа албан хаагчдын болон иргэдийн эрх ашигтай зөрчилдөж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулахад тус салбарыг хариуцсан омбудсмэн чухал үүрэг гүйцэтгэдэг.<sup>48</sup> Харин омбудсмэнүүд хувь хүн, төрийн бус болон төрөөс хараат бус бусад байгууллага, пүүс, компанийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг авч үздэггүй.

**3. Санал гомдол гаргах, түүнийг шалгах хэрэг үүсгэх, Омбудсмэний бүрэн эрх**

Ихэнх тохиолдолд омбудсмэний хянан шалгах ажлын үндэслэл нь омбудсмэний хамрах хүрээний байгууллага, албан тушаалтны гаргасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн шийдвэр, үйл ажиллагааны талаархи хувь хүний гомдол болдог. Эдгээр зөрчил нь харилцааны болоод үйл ажиллагааны нэлээд өргөн хүрээний үйлдлийг хамардаг байна. Жишээ нь, иргэдтэй бүдүүлэг харьцах, шударга бус, ялгавартай хандах, тэр бүү хэл Их Британид удирдлагын “муу” арга ажиллагаа ч иргэдийн гомдлын үндэс болдог байна.

<sup>48</sup> [www.se2.dcaf.ch/.../Files/.../ipu\\_hb\\_mongolian.pdf](http://www.se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf)

Мөн зарим улс оронд иргэдийн гомдлоос гадна омбудсмэн өөрийн санаачлагаар холбогдох хууль бусад актад тусгагдсаны дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Жишээ нь, Туркийн Хүний эрхийн хяналтын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор яам, агентлаг болон бусад төсвөөр санхүүждэг байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, их сургуулиуд, бусад нийтийн удирдлагын байгууллагууд болон хувийн секторын байгууллагуудаас мэдээлэл хүсэх, тэдгээрт хяналт шалгалт хийх, холбогдох этгээдийг дуудан мэдээлэл авах бүрэн эрхтэй байхаас гадна шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын үеэр илэрсэн зөрчлийг үнэн зөв магадлах үүднээс тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнээс мэдээлэл авч болдог.

Омбудсмэн нь иргэдээс гаргасан гомдлын дагуу хяналтын үйл ажиллагаа явуулдаг ч зарим оронд гурав дахь этгээд болон хувийн байгууллагын гомдлыг ч хүлээн авч болдог байна. Ихэнхи улсад аливаа иргэн омбудсмэнд шууд хандах эрхтэй. Хүний эрх зөрчсөн доголдол дутагдал ба эрх мэдлээ урвуулан ашиглах, алдаа зөрчилтэй, шударга бус шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох, төрийн удирдлага ба түүний албан хаагчдыг олон нийтийн өмнө хариуцлага хүлээлгэдэг болгох үүрэгтэй байдаг.

Уг зөрчил байдал илэрвэл омбудсмэн нь энэ тухай зохих байгууллага буюу албан тушаалтанд тэдгээрийг мэдэгдэж түүнийг арилгахыг заана. Тэрээр татгалзсан тохиолдолд шүүн таслах ажиллагааны байгууллага буюу парламентад хандаж болно. Гэхдээ омбудсмэн засгийн газар заавал биелүүлэх шийдвэрийг гаргах эрхгүй байдаг ба харин өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгдөг.

Төрийн байгууллагуудыг харьяалсан омбудсмэн эдгээр байгууллагуудад хамаарах өргөн эрхтэй байдаг. Зарим оронд шүүх, цагдаа, цэрэг зэргийг хамаардаг байхад зарим газар эдгээр нь омбудсмэны харъяалалд хамаардаггүй. Улс орнуудад омбудсмэны байгууллага гүйцэтгэх үүргээсээ хамааран бүрэн эрх нь янз бүр байх боловч дараахь бүрэн эрхийн хувьд нийтлэг байна:

1. Төрийн байгууллагын удирдлагын хуульд нийцээгүй буюу шударга бус үйл ажиллагаа хийсэн эсэхийг шалгах
2. Шалгалтын явцад захиргаа зохисгүй үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол энэ байдлыг арилгах зөвлөмж өгөх
3. Онцгой тохиолдолд хууль тогтоох байгууллагад хандах эрхтэй. Омбудсмэн нь жилийн ажлын тайлангаа олон нийтэд мэдээлэх ба хууль тогтоох байгууллагад тайлагнадаг.<sup>49</sup>

Ихэнх оронд Парламентын комисс болон тодорхой депутатуудын санал хүсэлт омбудсмэны хянан шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх үндэслэл болж өгдөг байна. Мөн ихэнхдээ омбудсмэнүүд өөрсдийн санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаагаа эхлүүлдэг. Болгарт анх 1998 онд Омбудсмэнийг байгуулах тухай хууль батлан гаргасан боловч 2005 онд анхны Омбудсмэнийг улсын болон мужийн гэсэн үйл ажиллагааны статустай байхаар сонгосон. Болгарт омбудсмэний талаар Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байх ба хуулийн 5 дугаар бүлэгт тус улсын парламентын хүний эрхийн омбудсмэн, үндэстний болон үндэстний цөөнхийн эрхийн парламентын омбудсмэны үйл ажиллагааны талаар зааж өгсөн.<sup>50</sup>

Улс орнуудын хууль тогтоомжид гомдол гаргахад тавигдах шаардлагын талаар зарим зүйлийг оруулсан байдаг. Үүнд нэргүй гомдлыг хүлээж авахгүй байх, гомдлыг бичгээр гаргах, (АНУ, Канадын зарим мужид утсаар гомдол гаргаж болдог), гомдолд татвар ногдуулахгүй

<sup>49</sup> [se2.dcaf.ch/.../Files/.../ipu\\_hb\\_mongolian.pdf](http://se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf)

<sup>50</sup> <http://net.jogtar.hu/jr/gen/getdoc.cgi?docid=94900020.tv&dbnum=62>



байх гэх мэт. Нөгөө талаар омбудсмэнд хандаж гаргасан гомдол нь тухайн асуудлаар урьд өмнө нь шүүхээр авч хэлэлцсэн эсхүл шүүхээр хэлэлцэхээр хүлээгдэж байгаа асуудал, гомдол байж болохгүй. Ер нь эрхийг хамгаалах бусад аргатай давхардахгүй байхыг хуульчилсан байдаг. Ихэнхдээ хуулиар тухайн асуудлыг хянан авч үзэх цаг хугацааны талаар заалт оруулсан байдаг. Тухайлбал ихэнхдээ эрх нь зөрчигдснөөс хойш 1-2 жилийн хугацаанд гомдлыг авч үзсэн байхаар заадаг.

Омбудсмэнд гаргасан гомдол бүрийг авч үзээд байдаггүй. Гомдлыг авч үзэх, эсэхийг омбудсмэн өөрөө шийддэг. Түүний энэ шийдвэр эцсийн байх бөгөөд энэ талаар ямар нэг санал гомдлыг хүлээн авахгүй. Их Британид гомдлыг хүлээн авах өвөрмөц дэгийг тогтоосон нь аливаа гомдол гаргагч этгээд түүнийгээ заавал парламентын гишүүнээр дамжуулан тавих ёстой ажээ. Энэ нь нэг талаас ирж буй гомдлын тоо хэмжээг бууруулан парламентын шүүлтүүрээр орох хүндрэлтэй боловч нөгөө талаар омбудсмэний анхаарлыг хүний эрхийг зөрчиж буй нэлээд түгээмэл, тархмал болон анхаарал татсан асуудалд хандуулах ач холбогдолтой гэж үздэг.

Омбудсмэний бүрэн эрх нн мэдээж түүний чиг үүргийн зорилтоос шалтгаална. Нийтлэг шаардлага нь гэвэл тухайн гомдолтой холбогдол бүхий аливаа шаардлагатай баримт бичгийг шаардаж гаргуулж авах, төрийн бусад хяналтын байгууллагад зарим тодорхой ажиллагаа зохион байгуулж хийхийг шаардах, шаардлагатай тохиолдолд омбудсмэний оффисоос санхүүжүүлэн шаардлагатай мэргэжилтэнг хянан шалгах үйл ажиллагаандаа татан оролцуулах эрхтэй байдаг байна. Хянан шалгах явцдаа төрийн тодорхой албан тушаалтаны үйл ажиллагаа нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байдал илэрвэл хэргийг шүүхэд шилжүүлнэ. Харин тухайн хэрэгтэй холбогдох баримт бичгийг омбудсмэний цуглуулсан мэдээлэл, материал зөвхөн түүний мэдлийн байх бөгөөд шүүх тэдгээрийг хэргийн баримт болгон ашиглах боломжгүй юм.

#### **4. Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр**

Ихэнх улс оронд омбудсмэн үйл ажиллагаагаа ганцаарчилсан байдлаар явуулдаггүй. Гол төлөв батлагдсан төсөвтөө багтаан оффис, товчоо байгуулан ямар орон тоотой ажиллахаа тодорхойлон гаргаж, түүнийгээ өөрөө удирдан ажилладаг байна. Оффис нь ихэвчлэн хэд хэдэн төрөлжсөн хэлтэс, байцаагчид болон шаардлагатай техник ажилтнуудаас бүрддэг. Гэхдээ тухайн орны хүн ам, хөгжил, уламжлал, гаргаж буй санал гомдлын тоо зэргээс шалтгаалж омбудсмэний оффисийн ажилтнуудын тоо харилцан адилгүй байдаг. Тухайлбал, АНУ-ын Айова мужид медиатор нь 5-6 хүнтэй оффистой байхад Нигер Улсад 1780 хүнтэй байсан тухай тэмдэглэгдсэн байдаг.

Зарим орны хуульд омбудсмэний оффист гаргасан санал гомдлыг ямар журмаар шийдвэрлэдэг дэгийн талаар товч оруулсан байдаг. Жишээ нь Канадын Колумбийн Британи мужийн Омбудсмэний тухай Актын 14, 15 дугаар зүйлд зааснаар гаргасан санал гомдлыг шалган тогтоох явцад болон эцсийн байдлаар шийдвэр гаргахаас өмнө талуудын хооронд харилцан эвлэрэх үе шат байхаар заасан байдаг байна.

Омбудсмэн гаргасан санал гомдлын мөрөөр шалгаад ямарваа нэг заавал биелүүлэх эрхийн хүчинтэй шийдвэр гаргадаггүй өвөрмөц онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага болон холбогдох албан тушаалтны буруутай үйл ажиллагааны уршгаар иргэний эрх зөрчигдсөн болох нь тогтоогдсон тохиолдолд омбудсмэн нь захиргааны буруутай шийдвэрийг өөрчлөх, эсхүл уг буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг төлүүлэхийг шаардсан зөвлөмж гаргах эрхтэй байдаг. Нөгөө талаар бас захиргааны байгууллагаас гаргаж байгаа шийдвэрийг илүү энэрэнгүй, боловсронгуй болгох талаар арай өргөн хүрээтэй зөвлөмж ч гаргаж болдог байна.

Туркын хувьд Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцитай Туркын Үндсэн хууль, бусад



хууль тогтоомж, хэрэгжүүлэлтийг нийцүүлэх зорилгоор шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тогтоож, эл зорилгоор хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санал болгох зэрэг бусад улсын адил нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна шаардлага гарвал гадаад орны хүний эрхийн зөрчлийг өөрийн санаачлагаар болон тухайн орны эрх бүхий байгууллагын хүсэлтээр хянан шалгаж гарсан үр дүнг тухайн улсын парламентад шууд эсхүл эрх бүхий байгууллагад хүргэдэг бөгөөд жил бүрийн тайландаа үйл ажиллагааны үр дүн, дотоодод болон гадаадад Хүний эрхийн хүндэтгэл, хэрэгжилтийн байдлын агуулгыг тусган бэлтгэдэг байна.

Мөн түүнчилэн омбудсмен нь шалгасан санал гомдлынхоо дагуу тухайн асуудлаар холбогдох хууль тогтоомж, шийдвэрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Парламент болон Засгийн газарт хандсан санамж бичиг гаргаж болдог байна. Үүний зэрэгцээ зарим оронд омбудсмен Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болдог жишиг ч бий. Харин омбудсмэний үйл ажиллагааны талаархи тайланг жил бүр парламентад бичгээр гаргаж тайлагнах асуудлыг заавал гүйцэтгэх ажлын нэг болгож хуульчилдаг байна.

### Омбудсмэний бүрэн эрхийн хугацааны талаархи харьцуулалт

Хугацаа	2 жил	3 жил	4 жил	5 - 6 жил	10 жил	Хязгаар байхгүй
Улс	Австрали	Финланд, Шинэ Зеланд, АНУ-ын зарим муж	Швед, Норвеги, Дани, АНУ-ын зарим муж	Канадын болон АНУ-ын зарим муж, Израль, Испан, ОХУ Турк	Канадын Нью Брансуик муж	Их Британи, Хойд Ирланд

\*\*\*

### Омбудсмэнийг томилох

Томилох байгууллага	Парламент	Ерөнхий сайдын санал болгосноор Парламент	Парламентын санал болгосноор Ерөнхийлөгч, Амбан захирагч, Хатан хаан	Амбан захирагч	Засгийн газар, Сайд нарын Зөвлөл
Улс	Швед, Финланд, Норвеги, Дани, АНУ-ын зарим муж, Португали, Испани, ХБНГУ-ын Рейнальд-Пфальц, Австри, ОХУ	Канадын Квебек муж	Их Британи, Хойд Ирланд, Шинэ Зеланд, Канадын зарим муж, Израиль	АНУ-ын зарим муж	Франц

Омбудсманы үндсэн шинж нь олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх явдал бөгөөд манай улсад Хүний эрхийн үндэсний комиссыг адилтган үздэг. Харин манай улстай ижил төстэй эрх зүйн тогтолцоотой зарим улс орнуудын холбогдох хууль тогтоомжийг судлан үзэхэд авлигын асуудлаархи омбудсмен гэсэн бүтэц байхгүй байна. Тухайлбал: Турк, Унгар, Словак, Болгар зэрэг улс. Харин авлигатай тэмцэх төрийн бие даасан статустай байгууллага байх бөгөөд энэ нь төр, төрийн байгууллагын үйл ажиллагаа ард түмэнд хүрэхдээ албан тушаалын хууль бус хүндрэлгүйгээр хүрч үйлчилдэг байхад хяналт тавьж ажиллах, төрийг авлигын сүлжээнд автуулахгүй байх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

\*\*\*